



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/196

Улаанбаатар хот

Нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн цахилгааны утас тоноглолыг шинэчлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6, 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Иргэд, оршин суугчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах ажлын хүрээнд Баянгол дүүргийн 2 дугаар хорооны 30 дугаар байрны цахилгааны утас, тоноглолыг шинэчлэх ажлыг шуурхай зохион байгуулсугай.
- 2.Нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн цахилгааны утас, тоноглолыг шинэчлэх ажлыг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Г.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.
- 3.Дээрх ажилд шаардлагатай 1,249,500 (нэг сая хоёр зуун дөчин есөн мянга таван зуу) төгрөгийг хавсралтаар баталж Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч (Б.Хонгорзул)-д зөвшөөрсүгэй.
- 4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Нарангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР

Баянгол дүүргийн Засаг даргын
2022 оны 05 дугаар сарын 2-ний өдрийн
1/198 дугаар захирамжийн хавсралт



НИЙТИЙН ЗОРИУЛАЛТАЙ ОРОН СУУЦНЫ
ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЦАХИЛГААНЫ УТАС
ТОНОГЛОЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

2022 оны 05 дугаар сарын 18

Улаанбаатар хот

| № | Материалын нэр | Хүчин чадал материал, хэмжээ | Хэмжээ нэгж | Нийт тоо хэмжээ э | Нэгж үнэ | Нийт үнэ |
|---|--------------------------|------------------------------------|----------------|----------------------------|-------------|-----------|
| 1 | Магистраль СИП кабель | Ф16*3+25*1 | м | 145 | 6,000 | 870,000 |
| 2 | Зэс утас | Ф2*2,5 | м | 60 | 3,500 | 210,000 |
| 3 | 3 фазын клем | | ш | 9 | 5,500 | 49,500 |
| 4 | Ажлын хөлс | | наряд | 1 | 120,000 | 120,000 |
| | Нийт | | | | | 1,249,500 |